

# БУЛГАН АЙМГИЙН 2023 ОНЫ 4 САРЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2023-05-08

Булган

2023 оны 4 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **21,7** тэрбум төгрөг буюу 110,4 хувийн, нийт зарлага **13,4** тэрбум төгрөг буюу 48,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

## 1. Төсвийн орлого

Нийт орлого ба тусламжийн дүн **21,7** тэрбум төгрөг буюу **110.4** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 4,2 тэрбум төгрөг буюу 24,3 хувь, урсгал орлого 4,0 тэрбум төгрөгөөр буюу 30,9 хувиар өссөн байна. Нийт орлогоос аймгийн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **15,7** тэрбум төгрөг буюу **117,6** хувийн, сумдын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **6,0** тэрбум төгрөг буюу **95,3** хувийн гүйцэтгэлтэй байна. Урсгал орлогын гүйцэтгэл **17,0** тэрбум төгрөг буюу **114,8** хувь байна.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр **2,791.2 сая**, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас **1,872,9 сая** төгрөг авсан байна.

Нийт орлогын 21,5 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 72.7 хувийг татварын орлого, 5,8 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Аймгийн дүнгээр авч үзвэл хувь хүний орлогын албан татвар, хадгаламжийн хүүгийн орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын дуудлага худалдааны орлого, ус рашааны нөөц ашигласны төлбөр, хөрөнгө борлуулсны орлого биелжээ. Бугат, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын татварын орлогын төлөвлөгөө биелсэн байна.

## 2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **13,428.3** сая төгрөг буюу **48,6** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **9,153.9** сая төгрөг буюу **40,2** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **4,274.4 сая** төгрөг буюу **87.9** хувь байна. Сумдад **5,086.4** сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангаас **230,0** сая төгрөгийн шилжүүлгийг олголоо.

Аймгийн Авто замын сангийн гүйцэтгэл 3,4 сая төгрөг буюу 0,8%, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 503,5 сая төгрөг буюу 17,8%, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 315,7 сая төгрөг буюу 7,7%, Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 181,8 сая төгрөг буюу 7,3% байна.

## 3. Төсвийн өглөг, авлага

Нийт өр **35,7** сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 0,6 сая төгрөгөөр буурч, өмнөх сартай харьцуулбал 4,4 сая төгрөгөөр өссөн байна. Нийт өрийн 97,5 хувь нь тогтмол зардлын өглөг байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС